





ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын компаниудын хувьцааны ханш хэлбэлзэлтэй байлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханш унажээ.

БНХАУ-ын аж үйлдвэрийн салбар уналтанд орж, худалдааны маргааны асуудал хүндэрсэн явдал зах зээлд сөргөөр нөлөөлөв. Харин АНУ-ын аж үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд сайжирч хувьцаануудын ханш өссөн байна.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны сар бүрийн тайлан гарч, өнгөрсөн 6-р сард нийт 213 мянган ажлын байр шинээр бий болсон нь 5-р сарын үзүүлэлтээс өндөр байгаа юм. Харин эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин 3.8%-аас 4.0% болон өсжээ.

Европ: Худалдааны маргааны асуудал хүндэрч, Европын компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Тус бүс нутгийн банк, уул уурхайн салбар болон авто машин үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш унажээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнчлэлээс татгалзан, авто машины импортод гаалийн татвар ногдуулна хэмээн мэдэгдсэнээр зах зээлийн индексүүд унав. Европын холбооны орнууд тус мэдэгдэлд хариу болгон 300 тэрбум ам. доллартай тэнцэх хэмжээний АНУ-ын бараа бүтээгдэхүүнд тариф ногдуулна хэмээн мэдэгдсэн билээ.

Английн төв банкны тэргүүн тус улсын үйлчилгээний салбар өсөж байгаатай холбогдуулан эдийн засаг сайжирч байгаа талаар мэдээлэв. Үүний дараагаас фунтийн ханш ам. долларын эсрэг чангарсан байна.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш 3 долоо хоног дараалж уналттай хаагдлаа. Иенийн ханш ам. долларын эсрэг 110.5 нэгж болж хаагдсан нь 2017 оны эцсээс 1.8%-аар чангарсан байна. Сүүлийн 2 сарын хугацаанд иенийн ханш ам. долларын эсрэг 110 нэгж орчимд хэлбэлзэж байгаа билээ.

АНУ-аас БНХАУ-ын 34 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний бараа бүтээгдэхүүнд ногдуулсан гаалийн татварын арга хэмжээ хэрэгжиж эхэлсэнээр Японы банк болон аялал жуучлалын салбарын компаниудын хувьцааны ханш унав.

Япон улсын Ерөнхий сайд Ноён Шинзо Абэ 2019 онд хэрэглээний татварын хэмжээг 8%-аас 10% болгон өсгөнө хэмээн мэдэгдсэн билээ. Шинжээчдийн үзэж буйгаар тус улсын инфляцийн түвшин зорилтот 2 хувьд хүрч, эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд татварын хэмжээ өсөхгүй хэмээн үзэж байна.

БНХАУ: Худалдааны маргааны асуудал хүндэрсэнтэй холбоотойгоор БНХАУ-ын компаниудын хувьцааны ханш унажээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,545.46	-2.08% ▼
Dow Jones	АНУ	24,456.48	0.76% ▲
S&P 500	АНУ	2,759.82	1.52% ▲
Nasdaq	АНУ	7,688.39	2.37% ▲
S&P/TSX	Канад	16,371.78	0.58% ▲
FTSE 100	Их Британи	7,617.70	-0.25% ▼
S&P/ASX 200	Австрали	6,272.30	1.25% ▲
Nikkei 225	Япон	21,788.14	-2.32% ▼
Hang Seng	Хонг Конг	28,315.62	-2.21% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	107.99
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	95.16
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	94.16
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	111.96
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.63
TDBM' 2020	USD	9.3%	105.53

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.086	0.06 ▲
Libor 3M	2.331	0.00 ▼
Libor 6M	2.508	0.01 ▲
Libor 1YR	2.774	0.01 ▲
US 6M Bond	2.103	0.00 ▲
US 2YR Bond	2.545	0.03 ▲
US 3YR Bond	2.644	0.04 ▲
US 5YR Bond	2.735	0.02 ▲
US 10YR Bond	2.840	0.00 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.07.06	Өөрчлөлт
USD	2,463.31	0.02% ▲
CNY	370.35	-0.38% ▼
EUR	2,882.81	0.70% ▲
RUB	39.03	-0.46% ▼
KRW	2.20	-0.45% ▼
JPY	22.28	0.09% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,255.48	0.38% ▲
Мөнгө /spot/	16.05	0.00% ▼
Зэс	282.40	-4.88% ▼
Нүүрс	113.12	1.61% ▲
WTI газрын тос	73.92	1.01% ▲
Brent газрын тос	77.11	-1.31% ▼
Байгалийн хий	2.85	-2.06% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. V	6.10%
Бодлогын хүү	2018. V	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. V	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. V	12.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. V	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. V	18.70%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. V	10.10%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 44 компанийн 1,249.8 сая төгрөгийн 6,247,690 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 24.21%-аар буюу хамгийн ихээр өсч 118 төгрөгт хүрч хаагдсан бол “Оллоо” /OLL/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 51.01 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 56 ширхэг үнэт цаас 5.6 сая төгрөгөөр арилжаалагджээ.


7-р сарын 6-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,415.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,545.46 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.08%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,255.4
Зах зээлийн үнэлгээ	2,415,596.6

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,545.46	-2.08% ▼
MSE I индекс	9,481.07	-3.49% ▼
MSE II индекс	9,650.70	0.17% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монинжбар	5,150,000	875,500,000
АПУ	135,981	80,955,671
Монгол базальт	121,589	48,600,333
Эрдэнэ ресурс	72,071	46,667,714
Девелопмент Корп		
Таван толгой	3,680	34,988,930

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	118.00	24.21% ▲
Монинжбар	170.00	13.33% ▲
Гутал	22,000.00	12.82% ▲
Материалимпекс	9,490.00	5.44% ▲
Монгол шуудан	588.88	1.84% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Оллоо	51.01	-15.00% ▼
Силикат	170.00	-15.00% ▼
Монгол шилтгээн	463.00	-14.89% ▼
Монгол секюритиес	403.03	-14.25% ▼
Атар-Өргөө	62,000.00	-11.30% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	1,891,064,084
Гаули	101,995,290
Бумбат-Алтай	80,111,882
Ард секюритиз	76,032,795
Ти Ди Би Капитал	67,836,229

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	595.00	633,188
Таван толгой	9,500.00	500,319
МИК	10,250.00	212,271
Говь	23,980.00	187,071
Сүү	216.00	74,304

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	56	5,600,000	100,000	100,000	104	14.820%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дүти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Хөвсгөл алтан дуулга” ХК нэмж үнэт цаас гаргахаар боллоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 06 сарын 29-ний өдрийн 262 тоот тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж байгаа нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4,405,600 ширхэг хувьцааг бүртгэж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа.

Нэмж гаргасан хувьцааны 3,328,600 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар стратегийн хөрөнгө оруулагч нарт нэг бүрийг нь 850 төгрөгөөр, 1,177,000 ширхэг хувьцааг олон нийтэд захиалга бүртгэлийн аргаар санал болгох бөгөөд доод үнийг 850 төгрөгөөр тогтоож анхдагч зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Ган хийц” ХК, “Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцааны ханш сүүлийн нэг жилд 7-20 хувиар өсөөд байна

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг 37 компани Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй байна. Үүнээс хувьцааны арилжаа нь идэвхтэй байдаг 19 компани байгаа ажээ.

Хувьцааных нь ханш урт хугацаандаа өссөн компаниудаас онцолбол “Ган хийц” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 20 орчим хувиар өсөж, 13 мянга 570 төгрөгт хүрээд байна. Ингэснээр тус компанийн зах зээлийн үнэлгээ 3.3 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа юм. “Ган хийц” компани олон нийтэд нээлттэй болсон цагаасаа хойш хувьцаа эзэмшигчдэдээ 12 удаа ногдол ашгаа тараагаад байна. 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 24.2 сая төгрөгийг тараажээ.

Харин Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй, барилгын материал үйлдвэрлэгч “Улаанбаатар БҮК” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 6.8 хувиар өссөн байна. Нэгж хувьцаа нь 425 төгрөгт хүрснээр Монголын Хөрөнгийн биржид тус компанийн зах зээлийн үнэлгээ 55.9 тэрбум төгрөгт хүрээд байгаа юм.

Сүүлийн гурван жилийн хугацаанд зогсонги байдалд байсан барилгын салбар сэргэж эхэлсэн талаар “Барилга МН” мэдээлж байна. Үнийн хувьд “Тэнхлэг зууч” компанийн тооцдог орон сууцны үнийн индекс сүүлийн зургаан сар дараалан өсөөд байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МИК: I улирлын байдлаар нийт 64 мянга 772 зээлдэгчийн ипотекийн зээлийг худалдаж авсан

Монголын ипотекийн корпораци ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргаж, улмаар орон сууцны найман хувийн зээлийн эх үүсвэрийг санхүүжүүлж байна. 2018 оны I улирлын байдлаар 14 удаагийн хэлцлээр 64 мянга 772 зээлдэгчийн зээлийг багцлан худалдан авч санхүүжилтээр хангаад байна. Монголын ипотекийн корпораци ипотекийн зээлийг буцаах нөхцөлгүйгээр багцлан худалдаж, тусгай зориулалтын компаниараа дамжуулан ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг гаргаж байгаа юм. Энэхүү үнэт цаас нь тогтмол хүүтэй, дотроо давуу эрхтэй болон энгийн бондоос бүрдэж байна.

Үүнээс гадна Монголын ипотекийн корпораци банкнуудын хөрвөх чадварыг сайжруулах, банкнуудаар дамжуулан иргэдэд орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны зээлийн хөрөнгийг багцлан худалдан авч байна. Нийт 59 удаагийн буцаах нөхцөлтэй буюу зээлийн эрсдэлийг зээл олгогч хариуцах нөхцөлтэй хэлцэл хийсэн талаар Монголын ипотекийн корпораци мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Азийн тогтмол орлоготой үнэт цаасны чуулга уулзалт”-аар орон сууцны санхүүжилтийн оновчтой шийдлийг хэлэлцлээ

Азийн тогтмол орлоготой үнэт цаасны чуулга уулзалтыг анх удаа Улаанбаатар хотод зохион байгууллаа. Энэхүү уулзалтаар орон сууцны тасралтгүй санхүүжилтийн сувгийг нээх олон улсын туршлагаас судлав.

Монголын ипотекийн корпораци тав дахь удаагийн чуулга уулзалтыг зохион байгуулах эрхийг албан ёсоор авсан байна. Энэхүү чуулга уулзалтаар “Орон сууцны бодлого ба санхүүжилтийн шийдлүүд” нэгдсэн сэдвийн хүрээнд орон сууцны бодлогын сонголтууд, санхүүжилтийн хувилбаруудын талаар хэлэлцэв. Хэлэлцүүлэгт Азийн тэргүүлэх долоон улсын ипотекийн хоёрдогч зах зээлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд оролцлоо.

“Чуулга уулзалт нь гишүүн орнуудын иргэд орон сууцны санхүүжилтийн дэмжлэг хүртэх, зээл авах, улмаар амьдралын чанарыг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд туршлага хуваалцах талбар” гэж Азийн ипотекийн хоёрдогч зах зээлийн холбоо мэдээлсэн юм. Тус холбооны гишүүн орнууд Монгол Улсад хэрэгжүүлж буй ипотекийн тогтолцоог өндрөөр үнэлж, үлгэр жишээ санхүүжилтийн систем гэж үзжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

УУХҮЯ: Цахиурын анхны үйлдвэр нээлтээ хийлээ

Дотоодын хүнд үйлдвэрлэлийн салбарт экспортын үйлдвэрийн тоо нэгээр нэмэгдлээ. Японы "Megatech" корпораци Дорноговь аймгийн Сайхандулаан суманд цахиур олборлох, баяжуулах үйлдвэр байгуулж, нээлтээ хийлээ.

Энэхүү үйлдвэр нь энэ төрлийн түүхий эдийг боловсруулж, экспортлох анхны үйлдвэр болж байна. 10 сая ам.долларын хөрөнгө оруулалттай энэхүү үйлдвэр сард 200-400 тонныг баяжуулах хүчин чадалтай талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. Мөн тус аймгийн Сайншанд суманд 20 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг хийж байгаа ажээ. "Megatech" корпораци нь Япон дахь өөрийн металлургийн үйлдвэрийн түүхий эдийг Монголоос бэлтгэн авах бэлтгэлээ ийнхүү хангаж байна.

"Megatech" корпораци цаашид боловсруулсан түүхий эдээ Япон, БНСУ, БНХАУ-ын зах зээлд нийлүүлэхээр төлөвлөсөн байна. Цахиур олборлох, баяжуулах үйлдвэрийг Дорноговийн Сайхандулаан суманд орших 400 жилийн нөөцтэй ордод түшиглэн байгуулжээ. Цаашид олборлолт, үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэхээр зорьж байгаа талаар тус компани мэдээллээ. Хоёр жилийн өмнө байгуулсан Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь бизнесийн хамтын ажиллагаанд түлхэц болж байгааг Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Масато Такаока онцолсон юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

"Terracom" компани I улиралд "Blair Athol" ордоос 374.6 мянган тонн нүүрс олборложээ

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Terracom" компани үйл ажиллагааны тайлангаа шинэчилсэн байна. Австрали дахь "Blair Athol" уурхайн нүүрсний борлуулалт 3-6 дугаар сард 374.6 мянган тонн болсон нь таамгаас 16 хувиар бага дүн болжээ. Харин борлуулсан нүүрсний дундаж ханш нь нэг тонн тутамд 102 австрали доллар болсон нь шинжээчдийн таамагтай дүйцсэн байна. Харин есдүгээр сард дуусах улиралд "Terracom" компани энэ уурхайгаас 583 мянган тонн нүүрсийг нэг тонн тутмыг нь 94 ам.доллараар борлуулахаар гэрээ байгуулсан гэдгээ мэдэгдлээ. "Terracom"-ийн хувьд Монголд Өмнөговь аймгийн нутагт байрлах Баруун Ноён Уул ордод олборлолт хийж байгаа аж.

Тус компанийн хувьцааны ханш мягмар гарагт Австралийн Хөрөнгийн биржид 0.4 австрали доллар боллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Эдийн засагт огцом өсөлт ажиглагдаж байгааг Дэлхийн Банк онцоллоо

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2 хувь, 2017 онд 5.1 хувь байсан бол энэ оны эхний улирлын байдлаар 6.1 хувьд хүрч огцом өсөлт ажиглагдаж байгааг Дэлхийн банкнаас гаргасан Монголын эдийн засгийн тойм тайланд онцолжээ. Гэхдээ богино болон дунд хугацааны эдийн засгийн төлөв эерэг хэвээр байгаа ч суурь бүтцийн эмзэг байдлыг арилгах тал дээр анхаарал хандуулах шаардлагатайг Дэлхийн Банкны эдийн засагчид зөвлөж байна.

Уул уурхайн салбарт үргэлжлэн их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт орохоор хүлээгдэж байгаагаас эдийн засгийн өсөлт цаашид нэмэгдэж, 2019-2020 онуудад дундаж өсөлт 6 хувийг давах төлөвтэй байгаа аж. Түүнчлэн боловсруулах, худалдаа, тээврийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэх хандлага ажиглагдсан байна. Экспорт үргэлжлэн нэмэгдэж, түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй байгаа учир эдийн засгийн өсөлт төсвийн алдагдал буурах нөхцөлийг бүрдүүлэх боломжтойг Дэлхийн Банкны Монгол Улсын хариуцсан ахлах эдийн засагч онцлов.

Тэрбээр "Түүхий эдийн үнэ өндөр хэвээр байна. Засгийн газраас эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаагийн үр дүнд 2017 он Монгол Улсын хувьд харьцангуй сайн жил байлаа. Энэ тааламжтай нөхцөл байдлын улмаас төсвийн болон гадаад сектор сайжирч, Засгийн газрын өр бага зэрэг буурч байна" хэмээв.

Эх сурвалж: Montsame.mn

Төв банк: ГВАН 3.26 тэрбум ам. долларыг давлаа

5-р сард Монгол Улсын гадаад валютын албан нөөц 3.26 тэрбум ам.долларт хүрч, 2013 оны 5-р сараас хойших дээд түвшинд хүрээд байна. Өөрөөр хэлбэл гадаад валютын албан нөөц 5-р сард өмнөх сараас 9.3 хувиар, жилийн дүнгээр 2.6 дахин өсөөд байгаа юм. 5-р сард төлбөрийн тэнцэл 201.7 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх сараас 248.7 сая ам.доллараар, өмнөх жилийн мөн үеэс 303.1 сая ам.доллараар тус тус сайжирсан үзүүлэлт болжээ. Төлбөрийн тэнцлийн ашиг нэмэгдэхэд дэлхийн зах зээл дэх эрдэс түүхий эдийн үнэ, Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн, Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд нийт 167.5 сая ам.долларыг Монгол Улсад олгосон зэрэг нь эергээр нөлөөлсөн байна. Цаашид төлбөрийн тэнцлийн ашиг өсөх хандлагатай байна гэж Монголбанк мэдээлж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.